



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

“Юу Эс Эй Эм Өү инвест” ХХК-д банк бус санхүүгийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Юу Эс Эй Эм Өү инвест” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Юу Эс Эй Эм Өү инвест ББСБ” ХХК /Б.Түмэндэлгэр/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

001523